<b>Дүн</b>	<b>189,844.7</b>	<b>147,594.2</b>	<b>(42,250.4)</b>

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Оны эцсийн нийт авлагын 89.4 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 7.8 хувийг байгууллагаас авах авлага, 2.8 хувийг ажиллагсадтай холбоотой авлага эзэлж байна.

*Хүснэгт 3. Байгууллагын авлагын үлдэгдэл /мянган төгрөг/*

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:		
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллагаас авах	Зээлийн авлага
1	ЗДТГ	3,400.00	100.2	100.2	0.0	0
2	ЕБС	1,618.70	12,568.7	2,618.7	9,950.0	0
3	Цэцэрлэг	0.00	2,975.6	1,455.6	1,520.0	-
4	СХС	184,825.99	131,949.7	0.0	0.0	131,949.69
	<b>ДҮН</b>	<b>189,844.69</b>	<b>147,594.2</b>	<b>4,174.5</b>	<b>11,470.0</b>	<b>131,949.7</b>
	<b>Дүнд эзлэх хувь</b>		<b>100</b>	<b>2.8</b>	<b>7.8</b>	<b>89.4</b>

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 105888.1 мянган төгрөг байснаас тайлант онд 88724.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст бараа материалын үлдэгдэл 194532.7 мянган төгрөг болсон байна.

*Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	59,721.2	87,291.9	27,570.7
Эм боох материал	1,217.8	9,221.3	8,003.5
Бичиг хэргийн материал	1,000.6	3,382.0	2,381.4
Аж ахуйн материал	6,233.8	13,327.7	7,093.9
Түлш, шатах тослох материал	-	4,800.0	4,800.0
Хүнсний материал	11,371.0	43.4	(11,327.6)
Барилгын засварын материал	-	1,633.9	1,633.9
Бусад хангамжийн материал	26,263.9	67,533.5	41,269.6
Нөөцийн бараа	-	7,299.0	7,299.0
<b>Дүн</b>	<b>105,808.1</b>	<b>194532.7</b>	<b>88,724.5</b>

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 88724.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсөвт байгууллагуудад бусад хангамжийн материал, эм боох материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 5. Байгууллагын бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	ИТХураал	ЗДТГазар	Сургууль	Цэцэрлэг	Соёл	ЭМТөв	ОНХС	Дүн
Эхний үлдэгдэл	288.0	15,136.6	42,616.5	26,473.8	4,414.0	16,879.4	-	105,808.1
Нэмэгдсэн	11,409.2	137,360.5	64,401.4	17,250.6	7,113.9	69,380.5	7,299.0	314,215.0
Худалдан авсан	10,773.2	59,272.0	51,241.4	17,250.6	7,113.9	49,353.9	7,299.0	202,304.0
Хандиваар ирсэн	-	78,088.5	-	-	-	20,026.5	-	98,115.0
Бусад	636.0	-	13,160.0	-	-	-	-	13,796.0
Хасагдсан	10,473.2	80,785.3	48,319.2	18,760.0	5,602.9	61,550.0	-	225,490.5
Худалдсан, зарцуулсан	10,473.2	78,836.8	48,319.2	18,760.0	5,602.9	50,092.7	-	212,084.8
Шилжүүлсэн	-	1,948.5	-	-	-	11,457.2	-	13,405.7
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>1,224.0</b>	<b>71,711.8</b>	<b>58,698.7</b>	<b>24,964.4</b>	<b>5,925.0</b>	<b>24,709.9</b>	<b>7,299.0</b>	<b>194,532.7</b>

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3179528.3 мянга, эцсийн үлдэгдэл 4931017.3 мянган төгрөг болж, 1751489.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	1,985,609.5	3,580,469.8	1,594,860.3
Тээврийн хэрэгсэл	166,457.9	184,342.9	17,885.0
Машин тоног төхөөрөмж	431,322.6	478,993.9	47,671.3
Тавилга эд хогшил	231,546.0	307,478.4	75,932.4
Номын фонд	10,041.8	10,091.8	50.0
Бусад үндсэн хөрөнгө	294,221.2	309,481.2	15,260.0
Программ хангамж	5,835.0	5,665.0	(170.0)
Бусад биет бус хөрөнгө	54,494.5	54,494.5	-
<b>Дүн</b>	<b>3,179,528.3</b>	<b>4,931,017.3</b>	<b>1,751,489.1</b>

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 31691.1 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 1496611.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагуудаас шилжүүлэн авч, 31213.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталжээ. Сумын сургуулийн 150 хүүхдийн дотуур байр 1420880.0 мянган төгрөгөөр баригдсан нь үндсэн хөрөнгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн байна.

*Хүснэгт №7. Байгууллагын үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	ИТХураал	ЗДТГазар	Сургууль	Цэцэрлэг	Соёл	ЭМТөв	Дүн
Эхний үлдэгдэл	15,948.53	1,307,210.89	411,426.87	480,039.72	255,132.10	709,770.15	3,179,528.26
Нэмэгдсэн	1,700.00	39,854.14	1,515,929.61	177,443.82	380.00	47,395.00	1,782,702.57
Худалдан авсан	1,700.00	3,580.00	17,318.10	2,098.00	380.00	6,615.00	31,691.10
Шилжүүлэн авсан	-	-	1,496,611.51	-	-	-	1,496,611.51
Бусад	-	36,274.14	2,000.00	175,345.82	-	40,780.00	254,399.96
Хасагдсан	0.00	23,350.00	200.00	7,663.50	0.00	0.00	31,213.50
Акталсан	-	23,350.00	200.00	7,663.50	-	-	31,213.50
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>17,648.5</b>	<b>1,323,715.0</b>	<b>1,927,156.5</b>	<b>649,820.0</b>	<b>255,512.1</b>	<b>757,165.2</b>	<b>4,931,017.33</b>

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрт урт хугацаат зээл байхгүй, богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 257.7 мянга, эцсийн үлдэгдэл 2767.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 2509.2 мянган төгрөгөөр өссөн нь ЕБС, Соёлын төвийн ажиллагсадтай холбоотой өглөг байна.

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:	
				Ажиллагсадтай холбоотой	Бараа үйлчилгээний зардлын өглөг
1	Эрүүл мэндийн төв	199.5	0.0	0.0	
2	ЕБС	58.3	2,762.3	2,762.3	
3	Соёлын төв	0.0	4.8	4.8	
<b>ДҮН</b>		<b>257.8</b>	<b>2,767.1</b>	<b>2,767.1</b>	<b>0.0</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4706284.6 мянга, эцсийн үлдэгдэл 4791022.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 84737.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	1,514,243.7	1,516,243.7	2,000.0	33.6
Хуримтлагдсан үр дүн	39,002.1	1,845,254.0	1,806,251.9	40.9
Өмнөх үеийн үр дүн	41,790.9	173,915.7	132,124.8	
Тайлант үеийн үр дүн	(2,788.8)	1,671,338.3	1,674,127.1	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,287,906.5	1,152,992.9	(134,913.6)	25.5
<b>Дүн</b>	<b>2,841,152.3</b>	<b>4,514,490.6</b>	<b>1,673,338.3</b>	<b>100</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4514490.6 мянган төгрөг болж өмнөх оноос 1673338.3 мянган төгрөгөөр өссөн нь сумын сургуулийн дотуур байрыг үнэ төлбөргүй авснаас шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

Жинст сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн хуралдааны 11/09 дүгээр тогтоолоор Жинст сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 4100.0 мянга, аймгийн төсөвт 85500.0 мянга, нийт 89600.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр төлөвлөгөөг 111.3 хувиар биелүүлснээс улсын төсөвт төвлөрөх татварын орлогыг 906.7 мянга, аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 3099.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №10. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>А. Улсын төсөв</b>	<b>4100</b>	<b>4695.5</b>	<b>595.5</b>	<b>114.5</b>
1. ААНБ-ын орлогын татвар	2000	1698.2	-301.8	84.9
2. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1500	1654.3	154.3	110.3
3. Агаарын бохирдол /авто/	600	1343	743	223.8
<b>В. Аймгийн төсөв /712/</b>	<b>85500</b>	<b>95032.3</b>	<b>9532.3</b>	<b>111.1</b>
1. ЦТХА орлого /Суутган -1/	75000	82418.5	7418.5	109.9
2. АТӨЯХ-ийн татвар	7700	10901.7	3201.7	141.6
3. ҮХЭХ-ийн татвар	1000	1069.5	69.5	107.0
4. Газрын төлбөр	1800	642.6	-1157.4	35.7
<b>Нийт дүн</b>	<b>89600</b>	<b>99727.8</b>	<b>10127.8</b>	<b>111.3</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Татварын орлогын биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл ААНБ-ын орлогын албан татвар, газрын төлбөрөөс бусад татварын орлогыг биелүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн хуралдааны 11/09 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 90400.0 мянга, хүү торгуулийн орлогыг 5500.0 мянга, нийт 95900.0 мянган төгрөгөөр баталсныг сумын ИТХ-ын 2020.09.25-ний өдрийн хуралдааны 13/03 дугаар тогтоолоор сумын 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн 50000.0 мянган төгрөгийн хасаж тодотгон, сумын нийт төсвийг 45900.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №11. Сумын төсөвт төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1.Татварын орлого</b>	<b>40,400</b>	<b>44,071</b>	<b>3,651</b>	<b>109</b>
1.1.ИОТХ	2,500.00	18,030.40	15,530.40	721.22
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	18,000.00	16,735.40	-1,264.60	92.97
1.3. ҮХЭХ борлуулсны татвар	0.00	430.00	430.00	0.00
1.3. Бууны татвар	1,000.00	845.60	-154.40	84.56
1.4.Улсын тэмдэгтийн хураамж	10,700.00	1,304.50	-9,395.50	12.19
1.5.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	6,000.00	6050.8	50.80	100.85
Түгээмэл тархацтай АМНАТ	1,000.00	250	-750.00	25.00
1.7.Газрын төлбөр	1200	403.9	-796.10	33.66
1.8. Нохойн татвар	0	20	20.00	#DIV/0!
1.9. Бусад татвар	0		0.00	#DIV/0!
<b>2.Татварын бус орлого</b>	<b>5,500</b>	<b>6,765</b>	<b>1,265</b>	<b>123.00</b>
2.1.Хүү торгуулийн орлого	5500	6765	1,265.00	123.00
<b>Нийт дүн</b>	<b>45,900.00</b>	<b>50,835.60</b>	<b>4,915.60</b>	<b>110.75</b>

Тайлант онд ИТОХ-ын төлөвлөгөөг 15530.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь “Эрдэнэс-тавантолгой” ХК-ийн 2019 оны ногдол ашгийг иргэдийн дансанд төвлөрүүлсний хувь хүний орлогын албан татварыг сумын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой ба төлөвлөөгүй үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараар 430.0 мянган төгрөг оржээ.

Тайлант онд төлөвлөсөн ихэнх татварын орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байгаад цаашид анхаарч татварын орлогыг зөв төлөвлөх, төлөвлөгөөг биелүүлж ажиллах нь зүйтэй байна.

Сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн хуралдааны 11/09 дүгээр тогтоолоор сумын ЗДТГ, ерөнхий боловсролын сургуулийн өөрийн орлогыг тус бүр 2000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба сумын ИТХ-ын 2020.09.25-ний өдрийн хуралдааны 13/03 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн өөрийн орлогоор төлөвлөсөн 1000.0 мянган төгрөгийг хасаж, гүйцэтгэлээр сумын ЗДТГ-т 700.0 мянган төгрөг оруулсан байна.

Дээрх тогтоолоор сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн орлогоор тайлант онд 95482.0 мянган төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 57537.7 мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 60.3 хувиар биелүүлсэн байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2064106.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1907819.2 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1821127.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 86691.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байхад сумын Эрүүл мэндийн төв төсвийн төслийг хүргүүлээгүй ба аймгийн ИТХТ-ын 2019.11.29-ний өдрийн 11/09 дүгээр тогтоолоор нийт 2072537.1 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	78,582.30	70,890.90	-7,691.40
Засаг даргын Тамгын газар	398,312.60	370,410.20	-27,902.40
Сургууль	409,106.30	654,671.20	245,564.90
Цэцэрлэг	276,874.16	246,221.00	-30,653.16
Эрүүл мэндийн төв		403,636.20	403,636.20
Соёлын төв	154,580.90	123,227.90	-31,353.00
Сум хөгжүүлэх сан		102,300.00	102,300.00
Орон нутгийн хөгжлийн сан		101,179.70	101,179.70
<b>Нийт дүн</b>	<b>1,317,456.26</b>	<b>2,072,537.10</b>	<b>755,080.84</b>

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн 11/09 дүгээр тогтоолоор анх баталсан 2072537.1 мянган төгрөгийг сумын ИТХ-ын хуралдааны 2020.09.25-ний өдрийн 13/03 дугаар тогтоолоор 134047.7 мянган төгрөгөөр бууруулсан ба ЕБС, Цэцэрлэгийн төсвийг аймгийн Засаг даргын 2020.10.27-ний өдрийн А/770 дугаар захирамжаар 24762.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 33193.3 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2064106.3 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1106274.8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 22134.6 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 87848.7 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 669709.3 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 45900.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 96482.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 35756.9 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 7644.1 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 2.8 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч, оны эцэст зардлын хэмнэлтээс 6756.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 35744.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 12. Байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН-ын төсөвт төвлөрүүлсэн	Улсын төсөвт төвлөрүүлсэн
Засаг даргын Тамгын газар	370,410.2	368,374.9	2,035.3	99.5	1745.3	
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	70,890.9	70,483.7	407.2	99.4	407.2	
Ерөнхий боловсролын сургууль	661,246.0	639,232.0	22,014.0	96.7	561.7	21452.3
Цэцэрлэг	231,215.4	217,822.3	13,393.1	94.2	1273.1	12119.9
Эрүүл мэндийн төв	403,636.2	401,454.5	2,181.7	99.5	6.5	2172.4
Соёлын төв	123,227.9	120,465.3	2,762.6	97.8	2762.6	
Орон нутгийн хөгжлийн сан	101,179.9	86,691.5	14,488.4	85.7		
Сум хөгжүүлэх сан	102,300.0	3,295.0	99,005.0	3.2		
<b>Нийт дүн</b>	<b>2,064,106.5</b>	<b>1,907,819.2</b>	<b>156,287.3</b>	<b>92.4</b>	<b>6756.4</b>	<b>35744.6</b>

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Жинст сумын байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1907819.2 мянган төгрөг буюу 92.4 хувьтай байгаа нь ОНХС-ийн төлөвлөсөн зардлыг 16195.4 мянга, Сум хөгжүүлэх сангийн төлөвлөсөн зардлыг 99005.0 мянга төгрөгөөр дутуу олгосон, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 16034.7 мянга, нормативт зардлыг 7454.7 мянган төгрөгөөр хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 40347.9 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт өгснөөс бараа үйлчилгээний зардалд 27789.4 мянган төгрөг зарцуулж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад 12048.5 мянган төгрөгийг олгож, сумын ЗДТГ санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийн 510.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 13. Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлага, төвлөрүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	Соёлын төв	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	НИЙТ
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>25,715.40</b>	<b>99.00</b>	<b>8,362.80</b>	<b>3,685.70</b>	<b>2,485.00</b>	<b>40,347.90</b>
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14000					14,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,700.00		8,362.80	3,685.70	2,485.00	23,233.50
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3015.4	99				3,114.40
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>25,205.40</b>	<b>99.00</b>	<b>8,362.80</b>	<b>3,685.70</b>	<b>2,485.00</b>	<b>39,837.90</b>
Бараа, ажил үйлчилгээний зардал	25,205.40	99.00			2,485.00	27,789.40
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			8,362.80	3685.7		12,048.50
<b>Төсөвт төвлөрүүлсэн</b>	<b>510.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>510.00</b>

Эх сурвалж: "Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

*Хүснэгт 11. Шилэн дансны мэдээлэл*

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	14	14	10	4	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, улсын төсөв болон ОН-ийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
2	Хагас жил	3	3	3	0	
3	Улирал бүр	2	8	8	0	
4	Сар бүр	5	60	58	2	1,3 дугаар сарын ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл
5	Тухай бүр	6	72	68	4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт
<b>Нийт</b>		30	157	147	10	

*Эх сурвалж. Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас*

**3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг гэрээт аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, менежментийн захидлаар 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, “Төсвийн шууд захирагчийн тайланг Сангийн яамны “Э-Тайлан”-нд шивэхдээ Төрийн сангийн хэлбэлзэл, аудитлагдсан санхүүгийн тайлантай тулгаж, үнэн зөв шивж буй эсэхэд хяналт тавьж ажиллах” зөвлөмж хэрэгжээгүй, алдаа давтагдан гарч байна.

**3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Жинст сумын Засаг даргын үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудитлагдсан тайлангаас 587960.8 мянган төгрөгөөр зөрүүтэй, нэмэлт санхүүжилтийн тайланд өмнөх оны 15579.7 мянган төгрөгийн зардлыг тусгаагүй зөрчлийг аудитын явцад залруулсан ба цаашид Засаг даргын нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдлийг үнэн зөв тайлагнаж, төрийн аудитын байгууллагад үнэн зөв, бүрэн илэрхийлсэн санхүүгийн тайланг ирүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний, эцсийн үлдэгдлийг аудитлагдсан санхүүгийн тайлантай тулган шалгахад нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайлангаар нэгтгээгүй, Э-тайланд орлого, зардлыг бөөн дүнгээр оруулсан, дансны ангилал зөрүүтэй оруулсан зэргээс шалтгаалж, аудитын явцад 151584.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс үр дүнгийн тайланд 15272.3 мянга, мөнгөн гүйлгээний тайланд 126926.4 мянга, төсвийн гүйцэтгэлийн тайланд 6901.2 мянга, нэмэлт санхүүжилтийн тайланд 2485.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

№	Байгууллагын нэр	Үр дүнгийн тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Нэмэлт санхүүжилтийн тайлан	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	148.5	26,331.6			26,480.1
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1,500.0	963.0			2,463.0
3	Ерөнхий боловсролын сургууль		3,003.3	360.0		3,363.3
4	Эрүүл мэндийн төв	13,487.8	8,937.0	-	2,485.0	24,909.8
5	Цэцэрлэг	136.0	1,000.0	361.2		1,497.2
6	СХС			6,180.0		6,180.0
7	ОНХС		86,691.5			86,691.5
<b>Дүн</b>		15,272.3	126,926.4	6,901.2	2,485.0	151,584.9

Дээрх алдааны дийлэнх хувь нь өмнөх оны орлого, зардлыг зөрүүтэй оруулсан, зардлын ангиллыг буруу илэрхийлсэн байснаас гадна төсвийн гүйцэтгэлийн тайланд байгууллагын ажиллагсдын болон сурагчдын тоог аудитын тайлангаас зөрүүтэй оруулсан алдаа гарсныг аудитын явцад э-тайлангийн тоогоор залруулав.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Сумын ОНХС-аас тайлант онд 7000.0 мянган төгрөгийн хивэг хорголжин тэжээл авч, сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн байхад ЗДТГ орлогод аваагүй, 6345.0 мянган төгрөгийн тэжээлийг иргэдэд тараасан байхад тэжээлийн үнийг сумын ОНХС-ийн харилцах дансанд төвлөрүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өвс тэжээлийн 6345.0 мянган төгрөгийг иргэдээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Төвлөрүүлэн захирагчид 177902.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллага аудитад хамрагдаж, сумын ИТХ-д итгэл үзүүлсэн байна.

№	Байгууллагын нэр	Аудит хийсэн байгууллагын нэр	Дүгнэлтийн хэлбэр
1	Засаг даргын Тамгын газар	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Зөрчилгүй
2	Ерөнхий боловсролын сургууль		Хязгаарлалттай
3	Эрүүл мэндийн төв	"Глобал капитал аудит" ХХК	Зөрчилгүй
4	Цэцэрлэг		Зөрчилгүй
5	Иргэдийн төлөөлөгчийн хурал	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Итгэл үзүүлсэн
6	Соёлын төв		Түүвэрт хамрагдсан
7	Орон нутгийн хөгжлийн сан		Түүвэрт хамрагдсан
8	Сум хөгжүүлэх сан		Түүвэрт хамрагдсан

Сургуулийн захирлын 2020.12.08-ны өдрийн А/103 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс нь хөрөнгийг тоолсон гэх боловч тооллогын бүртгэлийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, нягтлан бодогч тооцоог бодож тооцоо бодсон акт үйлдээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй тайлант онд нярвын хувийн харилцах дансаар 13165.0 мянган төгрөг дамжуулж хөрөнгө худалдаж авсан Е баримт болон ачаа тээврийн зардал төлсөн баримт байхгүй зэрэг зөрчлийг дахин давтан гаргасан, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулалгүйгээр халаалтын зардлаас 8760.0 мянган төгрөгийн хөрөнгө, дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас 6800.0 мянган төгрөгийн шатах тослох материал, үдийн цайны зардлаас 5200.0 мянган төгрөгийн шатах тослох материал тус тус бэлтгэсэн зөрчлийн улмаас сумын Ерөнхий боловсролын сургууль "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 төсвийн байгууллагад 266767.5 мянга, ОНХС-д 4780.0 мянга, нийт 271547.5 мянган төгрөгийн 24 алдаа, зөрчил илрүүлснээс 138653.9 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 7007.4 төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 65848.6 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага өгч, 60037.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг хүргүүлжээ.

Үзүүлэлт	ЗДТГ	Эрүүл мэндийн төв	Ерөнхий боловсролын сургууль	Цэцэрлэг	ОНХС	Дүн
Төлбөрийн акт	тоо	2	2	2		6
	дүн	2085.3		1805.6		7007.4
Албан шаардлага	тоо	2	2			4
	дүн	52683.6		13165.0		65848.6

<b>Зөвлөмж</b>	тоо	3	1	6	1	11
	дүн	20368.1	234.0	39435.5	0.0	60037.6
<b>Залруулга</b>	тоо			1	1	1
	дүн			133676.9	197	4780.0
<b>Нийт алдаа зөрчил</b>	тоо	7	1	11	4	1
	дүн	75137.0	234.0	189393.9	2002.6	4780.0

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар Э-тайлангийн эхний үлдэгдэл нь санхүүгийн тайлан гаргаж байгаа Acolous программын эхний үлдэгдэлтэй тохирч байгаа эсэхийг тулган баталгаажуулсан эсэхийг шалгах шаардлагатай байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

**3.1.1. Илрүүлэлт:** Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн орлого, зарлагын төрлийг санхүүгийн тайлангаас 151584.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

**3.1.2. Эрсдэл:** Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

**3.1.3 Өгсөн зөвлөмж:** Сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад тавих санхүүгийн албаны даргын хяналтыг сайжруулах.

**3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

### 3.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

**3.2.1. Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 7 зээлдэгч 26317.9 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлогыг төлөөгүй хугацаа хэтрүүлж, оны эцэст хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.7 дахь Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” заалтыг зөрчсөн байна.

**3.2.2 Эрсдэл:** Сангийн хөрөнгөөс олгосон зээл гэрээнд заасан хугацаанд төлөгдөхгүй сан хохирох, дараагийн зээлдэгч сангаас зээл авах боломжгүй болох.

**3.2.3 Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл авч хугацаандаа төлөөгүй 17 зээлдэгчийн 26317.9 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүг 2021

оны 06 дугаар сарын 25-ны дотор төлүүлэх арга хэмжээ авч, заасан хугацаанд төлөөгүй иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

### 3.3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.2.2 **Илрүүлэлт:** Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудаст тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

3.2.2 **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

3.2.3 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР


Б.ДОЛЖМАА 2021.03.25

Анхан шатанд хянасан:  
АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.03.25

Хоёр дахь шатанд хянасан:  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.03.25



## 5. Хавсралт 1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
2021.03.25			БНА-2021/12/СТА-ТТ3
Шалгагдсан байгууллагын нэр:		Жинст сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
<b>1.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан</b>					
1	Сумын ОНХС-аас тайлант онд 7000.0 мянган төгрөгийн хивэг хорголжин тэжээл авч, сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн байхад ЗДТГ орлогод аваагүй, 6345.0 мянган төгрөгийн тэжээлийг иргэдэд тараасан байхад тэжээлийн үнийг сумын ОНХС-ийн харилцах дансанд төвлөрүүлээгүй.	6345.0	Төлбөрийн акт тогтоосон.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Р.Батжаргал, П.Наранбаатар
2	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагын төрлийг санхүүгийн тайлангаас 151584.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.	151584.9	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Р.Батжаргал, П.Наранбаатар
3	Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 7 зээлдэгч 26317.9 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлогыг төлөөгүй хугацаа хэтрүүлж, оны эцэст хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.	26317.9	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Р.Батжаргал, П.Наранбаатар
4	Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны хуудаст 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Р.Батжаргал, П.Наранбаатар
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангийн алдааны дүн</b>		<b>184247.8</b>			
<b>Харьяа төсвийн байгууллагуудын дүн</b>					
<b>Ерөнхий боловсролын сургууль</b>					
1	Нярав Ч.Эрдэнэсүрэнгийн данс руу 9 удаагийн гүйлгээгээр 13165.0 мянган төгрөгийн шилжүүлж хөрөнгө, материал, тээврийн хөлсөнд төлсөн байна. Бэлэн мөнгөний зарцуулалтыг хянаж үзэхэд хөрөнгө худалдаж авсан Е-баримт байхгүй, ачаа ачсан тээврийн жолоочид бэлэн мөнгө хүлээлгэж өгсөн баримт байхгүй ХХОАТ-ийн суутгаж аваагүй байна.	1316.5	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
2	Сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэсэн "Эх бүрдэн" ХХК руу 2020.10.18-ны өдөр шинээр ашиглалтад орсон 240 хүүхдийн сургуулийн зураг төсөвт тусгагдаагүй байсан хувцасны өлгүүрийн өрөө, хяналтын жижүүрийн өрөө, хүлээлгийн коридорын таазны тохижилтыг хийлгүүлэхээр 4000.0 мянган төгрөгийг урсгал засварын зардлаас шилжүүлсэн байна.	4000.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж

**Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

3	Тайлант хугацаанд оруулбал зохих зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 129 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 20 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн бүхий орлогын 1 гүйлгээ 84324 мянга, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 61299.0 мянга, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 23238.7 мянган төгрөгийн мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан байна.	0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
4	Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын түүвэр хийж үзэхэд хүүхдийн хоолны зардалд 46197.5 мянган төгрөг төлөвлөгдөж гүйцэтгэлээр 29086,3 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнийг нярвын тайлан хүүхдийн хоолны мөнөтэй тулган шалгахад байрны хүүхдийн хоолны зардалд 13233.5 мянга, урд санхүүгийн тайлангийн төлбөрт 4327,3 мянга, онцгой байдлын шатахуунд 6800,0 мянга, дархлаа дэмжих бүтээгдэхүүнд 4725.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	11525.5	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
5	Урд оны санхүүгийн тайлангийн аудитаар нярвын дансаар дамжуулж 10070,8 мянган төгрөг шилжүүлж бэлнээр авч кассын тайлан гаргаагүй мөн Е баримт байгууллагуудаас авахгүй гүйлгээ хийсэн зөрчил илэрч зөвлөмж өгсөн байхад тайлант онд нярав Ч.Эрдэнэсүрэнгийн хувийн харилцах дансаар 13165.0 мянган төгрөг дамжуулж хөрөнгө худалдаж авсан Е баримт байхгүй, ачаа ачсан тээврийн жолоочид бэлэн мөнгө хүлээлгэж өгсөн баримт байхгүй байна.	13165.0	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
6	Сургуулийн төсөвт оны эцэст зохицуулалт хийлгэж "Санкомаркетинг монголиа" ХХК-аас сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950.0 мянган төгрөгийг шилжүүлж авлага үүсгэж Төсвийн тухай хуулийн 6.4 дэх заалтыг зөрчсөн байна.	9950.0	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
7	Тээвэр шатахууны зардалд 4100,0 мянган төгрөг батлагдсан ба гүйцэтгэлээр 9446.0 мянган төгрөгийг зарцуулсан ба 9446.0 мянган төгрөгийг ямар зардлаас гүйлгэн зарцуулсныг шалгаж үзэхэд тээвэр шатахууны зардлаас 4100.0 мянга, хоолны зардлаас 5200.0 мянга, багаж техник хэрэгслийн зардлаас 146.0 мянган төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан байна.	5200.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
8	"Их богдын ундарга" ХХК-д 2020.03.03-ны өдөр сургуулийн захирлын гарын үсэггүй 1800.0 мянган төгрөгийн төлбөрийн баримтаар сумын төрийн сангийн төлөөлөгч шатахууны гүйлгээг хийсэн байна.	1800.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
9	Халаалтын зардлаас зориулалт бусаар 8760.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд 2020.02.06-нд "ЭГО КОНСТРАКШН" ХХК руу 1500.0 мянган төгрөгийн жанамын үнэ, 2020.04.24-нд Гэрэлтүүлэн Констракшн ХХК руу 7260.0 мянган төгрөгийн цэвэр усны нөөцийн савыг тус тус худалдан авсан байна.	8760.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
10	Сургуулийн захирлын 2020.12.08-ны өдрийн А/103 дугаар тушаалаар тооллогын комисс томилогдсон байна. Тооллогын бүртгэлд тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, нягтлан бодогч хөрөнгийг тооллого тооцоог бодоогүй байна.	0	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж

**Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

11	Тайлант оны эхэнд хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд 181872.7 төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 2019 онд акталсан сургуулийн барилгын дахин үнэлгээний нэмэгдлийг данснаас хасаагүй байгаа тул 133676.9 мянган төгрөгийг өмнөх оны үр дүн рүү бичилт хийсэн.	133676.9	Санхүүгийн тайланд залруулсан	Дарга, нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
<b>ДҮН</b>		<b>189393.9</b>			
<b>Засаг даргын Тамгын газар</b>					
12	Оны эцэст шатахууны зардалд нэмж тодотгол хийж, НИК ХХК-д 4000.0 мянган төгрөгийг шилжүүлж, шатахууны үлдэгдэлтэй гарч бараа материал нөөцөлсөн байна.	2000.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
13	Тайлант онд олгосон 1706.0 мянган төгрөгийн бөхийн бай шагналаас 85.3 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаж төсөвт төвлөрүүлээгүй байна.	85.3	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
14	Сум дундын ойн анги тус суманд 77578.6 мянган төгрөгийн өвс тэжээл нийлүүлж, 24895.0 мянган төгрөгийн үнийг дансанд авч, 52683.6 мянган төгрөгийн авлагатай байхад сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд өвс тэжээлийн авлага, өглөг тусгаагүй байна.	52683.6	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
15	Жинст сумын Засаг даргын 3 захирамж болон 25040.0 мянган төгрөгийн 4 ажил гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.	0	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
16	Мөнгөн гүйлгээний журналын анхан шатны баримттай тулган шалгахад 14504.0 мянган төгрөгийн гүйлгээний анхан шатны баримт байхгүй, е-баримтгүй хийсэн гүйлгээний тоо их, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.	14504.0	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
17	Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2020.10.06-ны өдрийн 02 дугаар хуралдаанаар 1948.5 мянган төгрөгийн 200 боодол өвс, 4 шуудай хивэг актлах шийдвэр гаргасан ба байгууллагын даргын шийдвэр гаргаагүй дээрх хөрөнгийг акталсан ба акталж устгасан баримт материалыг анхан шатны баримтад үдээгүй байна.	1948.5	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
18	Үндсэн хөрөнгөд үндсэн хөрөнгийн шинж чанаргүй хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү оны эхэнд 351248.3 мянган төгрөг байсан нь тайланд онд өөрчлөгдөөгүй бөгөөд СТАУС-аар татагдсан үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүйд зарим хөрөнгийн дахин үнэлгээний дүн хасах тэмдэгтэй байгаа ба дахин үнэлгээний нийт дүн 7396.9 мянган төгрөг байна.	3915.6	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
<b>ДҮН</b>		<b>75137.0</b>			
<b>Цэцэрлэг</b>					
19	Тайлант онд НДШ-д 1455.6 мянган төгрөгийг илүү төлж авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн.	1455.6	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	В.Сангисүрэн, Б.Чулуундорж
20	2020 оны 12 -р сард ажилтнуудын хувийн хэрэглээний гэр интернэтийн цэнэглэлтэд 350.0 мянган төгрөгийг шилжүүлж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.	350	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Б.Пүрэвжаргал, Т.Болорцэцэг
21	Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй ба 149 мэдээллээс бүтэн жилээр байршуулах 4 төрлийн 4 мэдээлэл, хагас жилээр байршуулах 2 төрлийн 2 мэдээлэл, сараар байршуулах 2 төрлийн 3 мэдээлэл, тухай бүр байршуулах 4 төрлийн 13	0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Б.Пүрэвжаргал, Т.Болорцэцэг

**Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	мэдээлэл, нийт 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.				
22	Цалин, НДШ-ийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтаас түүвэрлэн үр дүнгийн тайлан, ХХОАТ, НДШ-ийн тайлантай тулгахад НДШ-ийн илүү төлөлтийн 197.0 мянган төгрөгийг илүү төлөөд зардлаар тайлагнасан	197.0	Санхүүгийн тайланд залруулсан	Дарга, нягтлан бодогч	Б.Пүрэвжаргал, Т.Болорцэцэг
	<b>ДҮН</b>	<b>2002.6</b>			
<b>Эрүүл мэндийн төв</b>					
23	Цалин, НДШ-ийн зардлыг анхан шатны баримтаас хөөн давтан тооцоолох явцад НДШ-ийн тайлан болон НДБ-тай тооцоо нийлсэн актаар өглөг, авлагын зөрүүгүй гарсан боловч НДХ-ээс ирүүлсэн тооцоогоор 234.0 мянган төгрөгийн илүү төлөлттэй гарсан нь хөнгөлөлттэй нөхцөлөөр шимтгэл төлсөн ажилтны шимтгэлийн хувь хэмжээний зөрүүний залруулгыг НД-ын байгууллага тухайн санхүүгийн тайлан гарснаас хойш хийж ирүүлсэнтэй холбоотой үүссэн авлага байна.	234.0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Б.Үүрийнтуяа, Ц.Төмөрбат
	<b>ДҮН</b>	<b>234.0</b>			
<b>Орон нутгийн хөгжлийн сан</b>					
24	Төсвийн гүйцэтгэлийн тайланд 4780.0 мянган төгрөгийн өвсний орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байхад үр дүн, мөнгөн гүйлгээ, Э-тайланд туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна.	4780.0	Санхүүгийн тайланд залруулсан	Дарга, нягтлан бодогч	Р.Батжаргал, Б.Цэдэвсүрэн
	<b>ДҮН</b>	<b>4780.0</b>			
<b>Төсвийн шууд захирагчийн тайлангийн алдааны дүн</b>		<b>271547.5</b>			

---oOo---